

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ
НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт:

“6.1.4. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр Засгийн газраас гаргаж буй шийдвэр, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, энэ хуульд нийцээгүй бол түүнийг нэн даруй хүчингүй болгох буюу цуцлах.”

2/ 11 дүгээр зүйлийн 11.1.6 дахь заалт:

“11.1.6.халдварлагдсан буюу халдварын сэжигтэй байж болзошгүй иргэний хувийн мэдээллийн нууцлалыг хамгаалах, иргэний хувийн болон гэр бүлийн нууцыг задруулахаас сэргийлэх, аливаа байдлаар ялгаварлан гадуурхагдах, нэр төрийг нь гутаан доромжлох нөхцөлд хүргэхгүй байх;”

3/ 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсэг:

“11.6. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргах шийдвэр, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй бол үүсэх үр дагаврыг тухайн шийдвэр, арга хэмжээг гаргасан байгууллага, албан тушаалтан хариуцан арилгана.”

4/ 12 дугаар зүйлийн 12.4 дахь хэсэг:

“12.1.4. өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хувийн мэдээллийг хамгаалуулах;”

5/ 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэг:

“12.5. Гадаад улсад байгаа Монгол Улсын иргэн эх орондоо буцаж ирэх, улсын хилээр нэвтрэх /орох/ эрхийг баталгаатай эдэлнэ.”

6/ 16¹ дүгээр зүйл.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үндэсний цахим мэдээллийн сан

“16¹.1. Засгийн газар энэ хуулийн 7.1.6, 7.1.11-т заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үндэсний цахим мэдээллийн сан”-г бүрдүүлж, ашиглана.”

“16¹.2. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үндэсний цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журмыг Засгийн газар батална.”

2 дугаар зүйл. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтад “Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай” гэсний дараа “хууль, Сонгуулийн тухай” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтад “хойшлуулах, сургалтын” гэсний дараа “болон дотуур байрны” гэж, 9 дүгээр зүйлийн 9.10 дахь заалтад “ерөнхий прокурор” гэсний дараа “, өмгөөлөгчийн ажиллах журмыг өмгөөлөгчийн үйл ажиллагааны нэгдсэн шаардлагад нийцүүлэн Монголын Өмгөөлөгчдийн холбоо” гэж, 9.11 дэх заалтад “шийдвэр гүйцэтгэх” гэсний дараа “, хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх” гэж, “11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтад “хандахыг хориглосон” гэсний дараа “болон өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтад “тусламж, үйлчилгээ” гэсний дараа “г үнэ төлбөргүй” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн дараах зүйл, заалт, хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

1/ 10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэг:

“10.7. Ипотекийн зээлийн эргэн төлөлтийн хугацааг зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хойшлуулах, зээлийн гэрээний хугацааг сунгах асуудлыг Засгийн газартай хамтран хэрэгжүүлнэ.”

2/ 15 дугаар зүйл. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цартахлаас

урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

○ үйл ажиллагааны санхүүжүүлэлт”

“15.1 .Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны санхүүжилт нь улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага, гадаад улс орноос өгч байгаа хандив болон хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.”

“15.2. Энэ хуулийн 15.1-д заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага, гадаад улс орноос өгч байгаа хандивыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.24-т заасан санд төвлөрүүлэх ба сангийн үйл

ажиллагааг олон нийтэд ил байлгаж, сангийн хөрөнгийг хуульд зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.”

4 дүгээр зүйл. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтад “тогтмол хяналт тавих.” гэснийг “тогтмол хяналт тавих;” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад “нөхцөл байдлыг харгалзан” гэснийг “нөхцөл байдлыг үл харгалзана” гэж, “үе шаттайгаар” гэснийг “шуурхай” гэж 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтын дугаарыг “12.1.5” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг